

## Монгол Улсын газрын тос, уул уурхайн ил болоогүй гэрээнүүд

Роберт Питман

Байгалийн баялгийн төслүүдийн эрх зүйн хүрээний чухал хэсгийг Монгол Улсын Засгийн газрын уул уурхай, газрын тосны компаниудтай байгуулсан гэрээ, тэдгээрийг дагалдах баримт бичгүүд бүрдүүлдэг. Эдгээр суурь баримт бичгийг ил болгож нийтлэх нь засгийн газар, компаниудын хувьд олборлох үйлдвэрлэлийн төслүүдийн талаарх олон нийтийн итгэлцэл, ойлголцлыг бэхжүүлэх боломжийг олгоод зогсохгүй Монгол Улсын ДНБ-ний тавны нэгийг бүрдүүлэгч эдийн засгийн үйл ажиллагаанд нэн шаардлагатай байгаа хариуцлагатай, тогтвортой байдлыг бий болгох юм.

Энэхүү хураангуйд Монгол Улс байгалийн баялгийн гэрээнүүдээ яагаад нийтлэх ёстойг тайлбарлаж (1-р хэсэг), Монгол Улсын олборлох салбарт байгуулагдсан, нийтэд ил болгох шаардлагатай гэрээнүүдийг танилцуулахын (2-р хэсэг) зэрэгцээ байгалийн баялгийн гэрээний ил тод байдлыг бодитойгоор хангах арга замуудыг санал болгов (3-р хэсэг).

### ГОЛ АГУУЛГА

- Хэдийгээр Засгийн газрын зүгээс гэрээг ил болгоно гэж амласан ч Монголд нийтийн өмч болох газрын тос, ашигт малтмалтай холбоотой чухал гэрээ хэлэлцээрүүдийн ихэнх нь нууц хэвээр байна.
- Нийтэд ил болсон гэрээнүүдийг нягталж үзэхэд төслүүдийн талаарх бизнесийн хувьд эмзэг мэдээллийг агуулах нь ховор байна. Түүнчлэн нууцын тухай заалтууд гэрээг ил болгох явдлыг хориглох үндэслэл болохгүйг нотолж байна.
- Монгол дахь гэрээний тогтолцоо ээдрээтэй бөгөөд олон төслийн хувьд хэд хэдэн гэрээ болон дагалдах баримт бичгүүдийг нийтлэх шаардлага үүсэж байна.
- Засгийн газар гэрээг олон нийтэд ил болгоход дараах 5 алхмыг хэрэгжүүлж болно: 1) гэрээний орчин нөхцөлийг тайлбарлах; 2) ил тод болгох цар хүрээг тодорхойлох; 3) гэрээ ил болгох дүрмийг тогтоох; 4) гэрээнүүдийг хүртээмжтэй болгох; 5) гэрээг ашиглахыг дэмжих.

## 1. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР УУЛ УУРХАЙ БОЛОН ГАЗРЫН ТОСНЫ ГЭРЭЭНҮҮДЭЭ ЯАГААД НИЙТЛЭХ ЁСТОЙ ВЭ?

### Засгийн газар нийтлэхийг зөвшөөрсөн

Засаглалыг бэхжүүлэх арга замуудын талаарх төр засаг, иргэний нийгмийн хамтын ажиллагааны санаачилга болох Нээлттэй засгийн түншлэлийн хүрээнд Монгол Улсын Засгийн газар “нийтийн баялгийг ашиглахтай холбогдуулан байгуулсан гэрээнүүдийн ил тод байдлыг хангах” үүрэг амлалт авсан. Үүнийг тус түншлэлийн 2016-2018 оны үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөний 11 дүгээр үүрэг амлалтад тусгажээ. Засгийн газрын тавьсан гол зорилтод гэрээний мэдээллийн сан байгуулах, улмаар тус санг олон нийтэд хүртээмжтэй болгох явдал орж байна.<sup>1</sup>

Засгийн газраас энэ амлалтаа хангалттай түвшинд биелүүлээгүй байна. Нээлттэй нийгэм форумаас Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын алба болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай хамтран байгуулсан Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санд<sup>2</sup> одоогоор 270 гаруй гэрээг байршуулж нийтэд ил болгоод байна. Үүнд орон нутгийн удирдлагуудтай байгуулсан 260 гаруй гэрээ болон зэс, алтны дэлхийн томоохон ордын нэг болох Оюу толгойн ордыг ашиглах талаар Засгийн газар ба Рио Тинто-ийн хооронд байгуулсан гэрээнүүд оржээ. Гэвч Оюу толгойн гэрээнээс өөр төв засгийн газартай байгуулсан бусад томоохон гэрээг албан ёсоор ил болгоогүй байна (2-р хэсгийг үзнэ үү).

Ихэнх гэрээг ил тод болгоход төр засагт хууль, эрх зүйн хүрээнд саад болох зүйл алга байна. Түүнчлэн засгийн газарт эдгээр баримт бичгийг бүгдийг биш гэхэд заримыг нийтэд ил болгоход шаардагдах батлагдсан хууль тогтоомж, бодлого бэлэн байгааг дурдах нь зүйтэй.

- 2014 оны Эрдэс баялгийн бодлогын 3.5.2-р зүйлд засгийн газар орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнүүдийг нийтлэх талаар заажээ.
- 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн 57.4-р зүйлд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлан, мөн байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлж болзошгүй химийн хорт болон бусад бодисын хэрэглээний талаарх мэдээллийг нийтэд нээлттэй болгох талаар заажээ.

Гэсэн хэдий ч бусад томоохон гэрээ, түүний дотор уул уурхайн хөрөнгө оруулалтын болон газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг нийтлэх хууль, эрх зүйн шаардлага байхгүй байна.

### Гэрээнүүдийг нийтлэх маргашгүй шалтгаанууд бий

**1. Иргэд нэрийнх нь өмнөөс байгуулсан төр засгийн аливаа хэлцэлтэй танилцах эрхтэй.** Монгол Улсын Үндсэн хуульд газрын тос, байгалийн хий, эрдэс баялаг нь “гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэж тодорхой заажээ.<sup>3</sup> Энэ нь Монгол Улсын Засгийн газар байгалийн баялгийн удирдлагын талаар компаниудтай гэрээ байгуулахдаа Монголын ард түмний нэрийн өмнөөс ажиллаж байна гэсэн үг. Иймд нэрийнх нь өмнөөс байгуулж гарын үсэг зурсан гэрээг иргэд үзэж танилцах, үнэлж дүгнэх боломжтой байх ёстой.

1 Монгол Улсын Засгийн газар, *Нээлттэй засгийн түншлэлийн Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө- II 2016-2018, 2016 оны 6 сарын 7, хуудас. 22-23.* [https://www.opengovpartnership.org/sites/default/files/Mongolia-NAP2-Final-Eng\\_0.pdf](https://www.opengovpartnership.org/sites/default/files/Mongolia-NAP2-Final-Eng_0.pdf)

2 <http://www.resourcecontracts.mn/> -с үзнэ үү.

3 Монгол Улсын Үндсэн хуулийн 6.1 дүгээр зүйл.

**2. Уул уурхай, газрын тосны гэрээнүүд иргэдийн амьдралд нөлөө үзүүлэхүйц чухал зохицуулалтуудыг агуулж байдаг.** Гэрээнд дараах чухал зохицуулалтууд агуулагддаг:

*Татвар, нөөц ашигласны төлбөр, бүтээгдэхүүн хуваах хувь гэх мэт татвар, санхүүгийн нөхцөлүүд болон үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн талаарх үүрэг амлалтууд*

Уул уурхайн салбарт татвар, санхүүгийн нөхцөл, үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн зорилт зэргийг агуулсан байж болох наанадаж таван төрлийн гэрээ байдаг. Газрын тосны салбарын хувьд эдгээрийг бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-нд оруулдаг. Эдгээр нөхцөл нь улсын төсөв, санхүүд асар их нөлөөтэй байж болно. 2016 онд Монгол Улсын төсвийн нийт орлогын 18.6 хувийг олборлох үйлдвэрлэлийн орлого бүрдүүлж байв. Тус орлого нь засгийн газрын хөтөлбөрүүд, түүний дотор, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх нэг гол эх үүсвэр болж байна. Эдгээр орлогыг тодорхойлогч нөхцөлүүдийг олон нийтээс нууц байлгавал иргэд олборлох үйлдвэрлэлийн төслүүдийн ашиг тусыг бүрэн ойлгоход улам бүр төвөгтэй болно. Ийм байдал нь Бороо голд, Петрочайна зэрэг зарим төслийг тойрсон маргаан бодит баримтуудад тулгуурлах гэхээсээ илүү уул уурхайн төлөө ба эсрэг гэсэн хоёр үзэлд хуваагдан туйлширч ирсний нэг шалтгаан юм.

*Байгаль орчинтой холбоотой үүрэг амлалтууд болон эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагууд*

Байгаль орчны хамгаалалт, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны асуудлаарх төслийн чанартай нөхцөлүүдийг орон нутгийн удирдлагуудтай байгуулах хамтын ажиллагааны гэрээнд заасан байж болно. Мөн тухайн төслөөс гаргадаг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, байгаль орчны тайлангуудад оруулдаг. Эдгээр нөхцөлэй танилцуулснаар иргэд тухайн төслийг илүү сайн ойлгодог болоод зогсохгүй байгаль орчны эрсдэлээс сэргийлэх, эрсдэлийг багасгах стратеги боловсруулж, хяналт тавихад нутгийн иргэний хувьд мэдлэг, туршлагаа хуваалцаж хувьд нэмрээ оруулах боломж бүрдэх юм.

*Дэд бүтэц, орон нутгийн ажиллах хүчин ба худалдан авалт, зөвлөлдөх шаардлагууд зэрэг нийгмийн хариуцлагууд*

Нийгмийн хариуцлагын асуудлыг олон янзын баримт бичигт, түүний дотор уул уурхайн хөрөнгө оруулалтын гэрээ, газрын тосны БХГ төдийгүй орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд ч тусгасан байж болно. Эдгээр нөхцөлийг нийтэлснээр иргэд тухайн төслөөс нийгэмд оруулж буй хувь нэмрийг ойлгоход туслаад зогсохгүй нийгмийн хөтөлбөрүүдийг нь боловсруулахад оролцож, тэдгээрийн үр шимийг хүртэх таатай боломжийг олгож байдаг. Мөн төр засаг ба компаниудын авсан үүрэг амлалтад хяналт тавьж, тэдгээрийн хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж өгдөг.

*Тогтворжуулалтын заалтууд*

Монголд байгаа уул уурхайн хөрөнгө оруулалтын гэрээнүүдэд аливаа төслийг хууль эрх зүйн хүрээнд орсон тодорхой өөрчлөлтөөс хамгаалах зорилготой тогтворжуулалтын заалтууд бий. Эдгээр нь тодорхой төрлийн шинэтгэлүүд, түүний дотор ихэвчлэн татвартай холбоотой, зарим тохиолдолд бусад асуудалтай холбоотой шинэтгэл хийх боломжгүй гэсэн утга агуулж болно. Тогтворжуулалтын заалтуудыг нийтлэх нь одоо хэрэгжиж буй төслүүдэд шинээр батлагдсан хууль тогтоомж үйлчлэх эсэхийг ойлгоход чухал үүрэгтэй. Түүнчлэн иргэд, төрийн албан тушаалтнууд тухайн шинэтгэлийг хийж чадах эсэхээ дүгнэж бодитой хүлээлттэй болоход чухал ач холбогдолтой.

**3. Гэрээг нийтэд ил болгох нь төрийн албан тушаалтнууд болон компанийн төлөөлөгчид хоорондоо тохиролцох нөхцөлүүдийнхээ хувьд хариуцлага хүлээх чухал боломжийг бүрдүүлдэг.** Хэлэлцээний талууд хийсэн ажлынх нь үр дүнг нийтэд ил болгож, хууль эрх зүйн болон арилжааны талаас нь нягтлан хянана гэдгийг мэдэж байгаа үед гэрээний төслөө илүү хянуур боловсруулах хүчтэй хөшүүрэгтэй болно. Улмаар тэднийг төр засгийн болон иргэдийн аль алиных нь зүгээс тэгш шударга гэж үзэхүйц гэрээг боловсруулахад тусална. Ялангуяа байгалийн баялаг ашиглах гэрээтэй холбоотой авлигын эрсдэлийн талаар болгоомжлол их байдаг Монгол Улсын хувьд нэн ач холбогдолтой асуудал юм. Тухайлбал, төрийн өмчит Эрдэнэт үйлдвэрийг Өмнөд Африкийн Стандарт банкнаас авсан 109 сая долларын барьцаанд тавьсан гэх асуудал бол эрсдэлийн нэг тод жишээ юм.<sup>4</sup>

**4. Гэрээг нийтлэх нь хууль эрх зүйн орчныг илүү найдвартай, тогтвортой болгодог.** Тухайн төслийг зохицуулж буй дүрэм журамтай хүн бүр танилцаж, ойлгох боломжтой нөхцөлд төр засаг уг дүрэм журмыг адил тэгш сахиулах, компаниуд тухайн дүрэм журмыг дагаж мөрдөх магадлал нэмэгддэг. Гэрээг нийтлэх нь төр засгаас дахин хэлэлцээ хийж, тохиролцох эрсдэлийг багасгадаг болохыг энэ салбарын мэргэжилтнүүд улам бүр хүлээн зөвшөөрөх болжээ. Монголд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг Рио Тинто, Орано гэх мэт дэлхийн уул уурхайн 27 том компанийг нэгтгэсэн салбарын байгууллага болох Уул уурхай, металлын олон улсын зөвлөлийн (УУМОУЗ) Ерөнхий захирал Том Батлерын хэлсэнчлэн, “Нээлттэй, ил тод гэрээг ч дахин хэлэлцэж болох хэдий ч гарын үсэг зурсан мөчөөс эхлэн гэрээ олон нийтийн хяналтад орох учраас ийм эрсдэл багасдаг” байна.<sup>5</sup>

### Гэрээний ил тод байдлын эсрэг нотолгоонуудыг хялбархан няцааж болно

Монголд гарч буй гэрээний ил тод байдлыг эсэргүүцэх нотолгоонууд гурван ташаа үндэслэлийг тойрч яригддаг бөгөөд тэдгээрийг хялбархан няцаах боломжтой.

Ташаа үндэслэл 1: Газрын тос, байгалийн хий, уул уурхайн гэрээний нууцлал бол бизнесийн тогтсон практик

Гэрээний нууцлал Монголд мөн түгээмэл байж болох ч дэлхийн бусад орнуудад салбарын энэ практик өөрчлөгдөж байна. Дэлхийн 44 улс олборлох үйлдвэрлэлийн гэрээнийхээ ядаж заримыг ил болгоод байгаа бол 27 улс газрын тос, уул уурхайн дор хаяж аль нэг салбартаа ил тод болгохыг шаардсан хуультай болоод байна.<sup>6</sup>

Олон улсын байгууллагууд ч гэрээг ил болгох зарчмыг үйл ажиллагааны удирдамждаа оруулж байна. 2007 онд Олон улсын валютын сангаас гаргасан Баялгийн орлогын ил тод байдлын удирдамжид олборлох үйлдвэрлэлийн гэрээнүүдийг нийтэд ил болгохыг уриалсан. 2010 онд Нэгдсэн Үндэсний Байгууллага (НҮБ)-ын бизнес ба хүний эрхийн тусгай төлөөлөгч Жон Раггий НҮБ-ын Хариуцлагатай гэрээний зарчмуудад гэрээний нөхцөлүүдийг ил болгох

4 UB Post, Жаст группын Ш. Батхүүг Эрдэнэт үйлдвэрийн өмчлөлийн асуудалд холбогдуулан баривчиллаа, 2018 оны 3 сарын 14, <https://www.pressreader.com/mongolia/the-ub-post/20180314/281492161837337>

5 Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга, Том Батлерийн асуулт, хариулт, УУМОУЗ-ийн Ерөнхий захирал гэрээний ил тод байдлын талаар, 2018 оны 7 сарын 11. <https://eiti.org/blog/qa-with-tom-butler-icmm-ceo-on-contract-transparency-policy>

6 <https://docs.google.com/spreadsheets/d/1FXEeD43jw6VYHV8yS-8KJ5-rR5l0XtKxVQZBWzr-ohY/edit#gid=0> Роб Питман ба Дон Хубэрт нарын, Эргэлтийн цэгийг давсан уу? ОУИТБС-ын хүрээн дэх гэрээний ил тайлагнал (Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн, 2017), 2 ба 27-р хуудас, <https://resourcegovernance.org/sites/default/files/documents/past-the-tipping-point-contract-disclosure-within-eiti-web.pdf>-с үзнэ үү.

зөвлөмжийг оруулсан. 2011 онд Олон улсын хуульчдын холбооноос гаргасан Уурхайг хөгжүүлэх загвар гэрээнд “энэхүү гэрээ нь нийтэд ил баримт бичиг байна” гэсэн заалт оруулжээ. Мөн 2017 оны Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргын дэргэдэх Дээд хэмжээний зөвлөх бүлгийн Авлигатай тэмцэх, шударга ёсыг хөхиүлэн дэмжих тухай тайланд гэрээг нийтэд ил болгох зөвлөмж оржээ. Газрын тос, байгалийн хий, эрдэс баялгийн сайн засаглалын дэлхий дахины стандарт болох Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын стандартад гэрээг ил болгох явдлыг 2013 оноос эхлэн дэмжиж ирсэн байдаг.

Олон улсын санхүүгийн байгууллагууд ч анхаарлаа хандуулж байна. 2012 онд Дэлхийн банкны хувийн хэвшлийн зээлдүүлэгч байгууллага болох Олон улсын санхүүгийн корпорац санхүүжилтийн шаардлагадаа тус байгууллагаас ерөнгө оруулсан газрын тос, байгалийн хий, уул уурхайн төслүүд “аливаа нөөц баялгийг ашиглах гол нөхцөл, болзлуудыг тогтоож засгийн газартай байгуулсан үндсэн гэрээ”-гээ ил болгох шаардлагыг нэмсэн байна. Монголын хувьд энэ дүрэм нь Оюу Толгой төсөлд үйлчилдэг бөгөөд тус төслийн гэрээнүүд нийтийн сүлжээгээр нийтлэгдсэн байдаг.<sup>7</sup> Хөгжиж байгаа орнуудад гадаадын шууд хөрөнгө оруулалтыг баталгаажуулдаг Дэлхийн банкны Олон талт хөрөнгө оруулалтын баталгааны газар ч дэмжлэг үзүүлж байгаа төслүүддээ үүнтэй төстэй шаардлагуудыг тавьдаг. 2013 онд Европын сэргээн босголт, хөгжлийн банк нүүрс устөрөгчийн төслүүддээ төстэй шаардлагуудыг мөн тусгасан байна.

Хувийн хэвшлийнхэн ч гэрээний ил тод байдлын үнэ цэнийг хүлээн зөвшөөрөх нь ихсэж байна. Газрын тос, уул уурхайн томоохон 40 компанийг хамарсан саяхны нэг судалгаагаар тэдний 18 нь гэрээний ил тод байдлын зарим хэлбэрийг дэмжиж байгаагаа нийтэд мэдэгдсэн байна. Үүнд Оюу Толгой төслийн нэг эзэмшигч Туркойз Хилл Ресурс-ийн гол хөрөнгө оруулагч бөгөөд дэлхийн уул уурхайн томоохон компанийн нэг болох Рио Тинто, мөн Тотал, Статойл, ВНР Биллитон, Ньюмонт, Баррик, Вале зэрэг бусад томоохон компани орж байна.<sup>8</sup> Эгнээндээ Рио Тинто, Ораног гишүүнээр нэгтгэсэн уул уурхайн салбарын дээвэр байгууллага УУМОУЗ ч бас гэрээний ил тод байдлын талаар бодлогоо тодорхойлсон (доорх Шигтгээ 1-ийг үзнэ үү). Өөр хэд хэдэн компани харьяа улсынхаа хөрөнгийн биржийн тайлангийн шаардлагад нийцүүлэх үүднээс гэрээнүүдээ ил болгож нийтэлдэг байна. Тухайлбал, Монголд ажиллаж байгаа DWM Petroleum AG компани 2009 онд Цагаан элс-XIII, 2008 онд Зүүнбаян-XIV хайгуулын талбайд хийсэн БХГ-ээ АНУ-ын Үнэт цаас, биржийн комисст илгээсэн хөрөнгийн биржийн тайландаа оруулсан байдаг бол Сторм Кэт Энержи Корпораци 2004 онд газрын тосны хайгуулын Нэмэгт-VI, Борзон-VII талбайд байгуулсан БХГ-ээ Канадын Үнэт цаасны захиргаанд ирүүлсэн тайландаа тусгажээ.<sup>9</sup>

7 <http://ot.mn/agreements/> -с үзнэ үү.

8 Изабэл Мунилла ба Кэтрин Брофи, Гэрээний ил нийтлэлийн судалгаа 2018, Оксфам Америк, <https://policy-practice.oxfam.org.uk/publications/contract-disclosure-survey-2018-a-review-of-the-contract-disclosure-policies-of-620465>

9 <https://www.sec.gov/Archives/edgar/data/1074447/000106299309002609/exhibit10-51.htm> ба <https://www.sec.gov/Archives/edgar/data/1074447/000106299309002609/exhibit10-52.htm>-г үзнэ үү. Эдгээр гэрээ дуусгавар болсон гэдгийг анхаарна уу.

### Шигтгээ 1 – УУМОУЗ-ийн гэрээний ил тод байдлын талаарх бодлого

УУМОУЗ-ийн гишүүн компаниуд 10 зарчим, тэдгээрийг дэмжсэн найман байр суурийн мэдэгдлийг дагаж мөрдөх шаардлагатай байдаг. Эдгээр байр суурийн мэдэгдлүүд бол УУМОУЗ-ийн гишүүн компанийн гүйцэтгэх ерөнхий захирлуудын биечлэн гарын үсэг зурж баталгаажуулсан бодлогын амлалт бичиг юм.

Энэхүү найман байр суурийн нэг болох Эрдэс баялгийн орлогын ил тод байдлын тухай мэдэгдэлд зөвлөлийн гишүүд “гэрээний заалтуудын... ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн зохих санаачилгуудад, ганцаарчлан эсхүл УУМОУЗ-өөр дамжуулан хамтдаа, тэгш шударга зарчмаар, бүтээлчээр оролцохыг” шаардсан заалт байдаг.

Монголын хувьд энэ шаардлага нь Оюу Толгой төслийн дийлэнх хувьцаа эзэмшигч Рио Тинто, Туркойз Хилл, мөн ураны орд ашиглалтын гурван тусгай зөвшөөрөлтэй, саяхнаас Зөөвч овоогийн ордод туршилтын журмаар олборлолт эхлээд байгаа Орано компанид үйлчилж байна.

Ташаа үндэслэл 2: Гэрээнүүд нь бизнесийн эмзэг мэдээлэл агуулсан учраас тэдгээрийг ил болгох нь өрсөлдөх чадварт хохирол учруулна.

Газрын тос, байгалийн хий, эрдэс баялгийн гэрээнүүд тухайн төслийн тухай бизнесийн хувьд эмзэг мэдээлэл агуулах магадлал бага байдаг. Монголд хэрэгжиж буй дөрвөн төслийн засгийн газартай байгуулсан гэрээг нягталж үзэхэд компаниуд тендерт оролцож байгаа, гэрээний хэлцэл хийж байгаа үед зарим нөхцөлүүд нь бизнесийн эмзэг мэдээллийг агуулж байж болох боловч нэгэнт гэрээ байгуулаад, гарын үсэг зурсны дараа ил болгосон тохиолдолд эдгээр нөхцөлийн аль нь ч компанийн өрсөлдөөний байр суурьд бодитой хохирол учруулах магадлал үндсэндээ байхгүй байна.<sup>10</sup>

Компанийн баримт бичгийг нууц байлгах нэг бодит шалтгаан бол тэдгээрт “арилжааны нууц” агуулагдсан байж болох явдал юм. Арилжааны нууц бол жинхэнэ эмзэг мэдээлэл бөгөөд түүнийг нууц байлгах бодитой үндэслэл компаниудад байдаг. Ийм мэдээллийн жишээнд аливаа компанийн технологийн нууц эсхүл ирээдүйд хийгдэх хэлцлийн тухай мэдээлэл ордог. Харин Монголд буй загвар гэрээнүүдийг нягталж үзэхэд олборлох үйлдвэрлэлийн гэрээнүүд дотор энэ төрлийн нөхцөлүүд огт байхгүй байгаа нь харагдаж байна. Үүний шалтгаан бол олборлох үйлдвэрлэлийн гэрээг компаниудын консорциумтай байгуулах боломжтой, консорциум доторх компаниуд цагийн аясаар өөрчлөгдөх нь түгээмэл байдагтай холбоотой. Энэ нь компаниуд анх гэрээ байгуулахдаа л өрсөлдөгч нь түүнийг олж үзэх боломжтой гэдгийг мэдэж байна гэсэн үг. Ийм тохиолдолд ямар ч компани гэрээндээ арилжааны нууцаа оруулж эрсдэл хүлээхгүй нь ойлгомжтой.

Бизнесийн хувьд эмзэг мэдээлэлд санаа зовох явдал харьцангуй бага болсныг эдүгээ олон компани ойлгож эхлээд байна. Саяхан Рио Тинто группийн Корпорацийн харилцааны гүйцэтгэх захирал Саймон Найвен ярихдаа мэдээллийн нууцлал ба бизнесийн хувьд эмзэг байдал нь “биднийг засгийн газруудтай байгуулсан гэрээнүүдийнхээ дийлэнх олонхыг ил болгоход саад болоогүй бөгөөд тэдгээр гэрээний ихэнх нь бизнесийн эмзэг мэдээлэл

<sup>10</sup> Эдгээр нь: Туркойз Хилл Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээ; DWM Petroleum AG компанийн 2009 онд Цагаан элс-ХIII, 2008 онд Зүүнбаян-ХIV хайгуулын талбайд хийсэн бүтээгдэхүүн хуваах гэрээ; Сторм Кэт Энержи Корпораци 2004 онд газрын тосны хайгуулын Нэмэгт-VI, Борзон-VII талбайд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ.

агуулаагүй байсан” гэжээ<sup>11</sup>. Үүний нэг адилаар, Тотал компанийн Хайгуул, олборлолт хариуцсан Ерөнхийлөгчийн Ахлах зөвлөх Жан-Франсуа Лассалл “аливаа улс газрын тосны бүх гэрээгээ нийтлэхийг хүссэн тохиолдолд бидний хувьд эрх зүйн болон арилжааны асуудлуудыг нь шийдвэрлэсэн гэж үздэг” гэж цохон тэмдэглэсэн байна.<sup>12</sup>

Ташаа үндэслэл 3: Тодорхой төслүүдийн хувьд гэрээнд орсон нууцлалын заалтууд болон нууцлалын гэрээ нь гэрээг ил болгохыг зөвшөөрдөггүй.

Засгийн газартай байгуулсан нийтэд ил гэрээ болон нууцлалын гэрээг тойрсон холбогдох хууль тогтоомжтой танилцаж үзэхэд Монголд гэрээг ил болгоход нууцлалын заалтууд саад болж байна гэж үзэх ямар ч үндэслэл байсангүй. Үнэн хэрэгтээ эдгээр гэрээний нэг буюу Оюу толгойн уурхайн гэрээний 15.21-р зүйлд уг баримт бичгийг “нийтэд ил болгоно” гэж тусгайлан заасан байна<sup>13</sup>.

Засгийн газартай байгуулсан нууцлалын заалт бүхий гурван гэрээний хувьд холбогдох заалтууд нь ихээхэн төстэй байв. (Шигтгээ 2-оос нууцлалын нийтлэг заалтын жишээг үзнэ үү). Эндээс үзэхэд ийм заалтууд нь гагцхүү хайгуул, үйлдвэрлэл, техникийн тоо баримттай холбоотой нууцлалд анхаарсан боловч гэрээ өөрөө нууцлалын шаардлагад хамаарна гэсэн үг үсэг огт байхгүй байгаа нь илэрхий байна. Тухайн заалт гэрээнд хамаарна гэж ойлгосон ч гэсэн уг шаардлагыг илэрхийлэхдээ гэрээнд оролцогч талууд хоёул зөвшөөрсөн тохиолдолд гуравдагч талд ил болгох боломж олгосныг онцлох нь зүйтэй. Энэ нь тухайн засгийн газар, компани хоёр зөвшөөрвөл ил болгож болно гэсэн үг. Мөн энэ заалтад “холбогдох хуульд нийцүүлэн” ил болгохыг зөвшөөрсөн байна. Энэ бол чухал заалт. Яагаад гэвэл Монгол Улсын эсхүл аль нэг улсын төр засаг хууль батлан гаргах замаар ил болгохыг шаардаж болно гэсэн үг. Эцэст нь, “гэрээний аль нэг тал эсхүл түүний хамаарал бүхий этгээдийн хувьцаа нь бүртгэгдсэн хөрөнгийн биржийн” дүрэм журам, зохицуулалтын дагуу ил болгохыг энэ заалт зөвшөөрсөн байна. Улмаар Монголд байгаа компаниудын хувьд хөрөнгийн биржийн тайландаа гэрээгээ оруулж ил болгоход саад болох зүйл байхгүй бөгөөд дээр дурдсанчлан ийм явдал Монголд байгуулсан гэрээнүүдийн хувьд дор хаяж гурван удаа тохиолдоод байгаа юм.

11 “Рио Тинтод тавьсан асуулт, хариулт”, ОУИТБС, 2018 оны 6 сарын 28, <https://eiti.org/blog/qa-with-rio-tinto>

12 “Тоталд тавьсан асуулт, хариулт”, ОУИТБС, 2018 оны 4 сарын 10, <https://eiti.org/blog/qa-with-total-first-major-to-adopt-contract-transparency-policy>

13 Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээ – 2009 оны 10 сарын 6, [http://ot.mn/media/ot/content/about\\_us/IA/Oyu\\_Tolgoi\\_IA\\_MN.pdf](http://ot.mn/media/ot/content/about_us/IA/Oyu_Tolgoi_IA_MN.pdf)

## Шигтгээ 2 – Нууцлалын заалтын жишээ: DWM Petroleum AG PSC компани, Зүүнбаян XIV талбайд 2008 онд байгуулсан гэрээ

### **Заалт 12: Хайгуул, үйлдвэрлэл, техникийн өгөгдөл мэдээлэл**

#### *12.10 Нууцлал*

Талууд үүгээр энэхүү XII зүйлд дурдсан бүх баримт бичиг, тайланг нууцад хамруулах, нөгөө талын зөвшөөрөлгүйгээр аливаа гуравдагч талд задруулахгүй байх үүрэгтэй.<sup>14</sup> Энэхүү нууцлал нь дараах мэдээлэлд хамаарна:

1. Аль нэг тал ажилтнууддаа ил болгох. Харьяа газар, зөвлөхүүд, ирээдүйн эрх хүлээн авагчид, ирээдүйн зээлдүүлэгчид, туслан гүйцэтгэгч нартаа Газрын тосны үйл ажиллагааны дүрэмд шаардсан нөхцөлд; эсхүл
2. Аль нэг тал холбогдох хуульд заасан хэмжээгээр эсхүл аль нэг талын буюу түүний харьяа газрын хувьцаа бүртгэлтэй байгаа хөрөнгийн биржийн журам, зохицуулалтад заасан нөхцөлөөр ил болгох.
3. Гэрээлэгч нь ирээдүйн боломжит хөрөнгө оруулагчийнхаа талаар Ашигт малтмал, газрын тосны газарт мэдэгдэнэ. Боломжит хөрөнгө оруулагч нь мэдээллийн нууцыг хадгалахаа баталгаажуулна.

Монголд буй компаниуд засгийн газарт хандаж “нууцлалын гэрээ” байгуулах хүсэлт гаргаж болно. Монголд мэдэгдэж байгаа ийм гэрээ ганц байгаа нь Арева Монгол ХХК-тай байгуулсан байдаг. Энэ гэрээ нийтэд ил болоогүй, агуулгыг нь үзэх боломжгүй бөгөөд ийм гэрээ байгуулахыг зөвшөөрсөн хууль тогтоомжуудтай танилцаж үзэхэд (Шигтгээ 3-аас үзнэ үү) Монголд хийгдэж буй нууц хадгалах гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн боловсруулсан хайгуулын тайлан, уурхайн ашиглалт, техник эдийн засгийн үндэслэлтэй холбоотой мэдээллийг хамарч байна. Харин энэхүү нууцлалд засгийн газар ба компаниудын хооронд байгуулсан гэрээг хамруулна гэсэн зүйл заалт огт байхгүй байна.

<sup>14</sup> Хайгуул, үйлдвэрлэл, техникийн тоо баримттай холбоотой зүйл.



### Шигтгээ 3 – Монгол дахь нууцлалын гэрээнүүдийн хууль, эрх зүйн үндэс

#### Ашигт малтмалын тухай хууль (2006 он)

57.2 Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигчийн боловсруулсан хайгуулын тайлан, уурхайн ашиглалтын мэдээ, техник, эдийн засгийн үндэслэлийг түүний хүсэлтээр тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаанд нууцад хамааруулах бөгөөд мэдээ, тайланг хүлээлгэн өгөхдөө нууц хадгалах талаар гэрээ байгуулж болно.

#### Цөмийн энергийн тухай хууль (2011 он)

11.7. Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 15.1.5-д заасан үйл ажиллагаа эрхлэх [цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх] тусгай зөвшөөрөл эзэмшигчийн боловсруулсан хайгуулын тайлан, техник, эдийн засгийн үндэслэл, энэ хуулийн 15.1.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх [цацраг идэвхт ашигт малтмал ашиглахтай холбоотой] тусгай зөвшөөрөл эзэмшигчийн боловсруулсан уурхайн ашиглалтын мэдээ, техник, эдийн засгийн үндэслэлийг түүний хүсэлтээр тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаанд нууцад хамааруулна.

#### Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль (2014 он)

38.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга тусгай зөвшөөрөл эзэмшигчийн боловсруулсан хайгуулын тайлан, уурхайн ашиглалтын мэдээ, техник, эдийн засгийн үндэслэлийг түүний хүсэлтээр тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаанд нууцад хамааруулах бөгөөд мэдээ, тайланг хүлээлгэн өгөхдөө нууц хадгалах талаар гэрээ байгуулж болно.

## 2. ЗАСГИЙН ГАЗАР ЮУГ НИЙТЛЭХ ЁСТОЙ ВЭ?

Энд дурдаад байгаа үндэслэлүүд нь засгийн газрын хэрэглэдэг төрөл бүрийн гэрээ, тэдгээрийг дагалдах баримт бичигт хамаарна. Монгол дахь гэрээний тогтолцоо харьцангуй нарийн төвөгтэй учраас энэ хэсэгт Монголд түгээмэл хэрэглэгддэг уул уурхайн болон газрын тосны гэрээнүүдийг авч үзэх бөгөөд эдгээр нь гэрээний үнэ цэнэ эсхүл гэрээтэй холбоотойгоор байгаль орчинд болон нийгэмд үзүүлэх үр нөлөөний учрыг олоход иргэдэд тустай нөхцөлүүдийг агуулсан байдаг. Тодорхой гэрээ, тэдгээртэй холбоотой баримт бичгийг энэ хэсэгт тодотгон тэмдэглэсэн болно.

### Уул уурхайн салбарын гэрээнүүд ба холбогдох баримт бичгүүд

Уул уурхайн компаниуд үйл ажиллагаа явуулахдаа Монгол Улсын Засгийн газраас тусгай зөвшөөрөл авах шаардлагатай. Компани тусгай зөвшөөрөл авснаар хуульд заасан дүрэм журмын дагуу эрдэс баялгийн хайгуул, олборлолт хийх боломжтой болно. Гэвч бодит байдал дээр, ялангуяа төсөл үйлдвэрлэл ашиглалтын шатанд орох үед компаниуд засгийн газар болон орон нутгийн засаг захиргаатай, мөн заримдаа Монголын төрийн өмчит үйлдвэрийн газруудтай олон тооны нэмэлт гэрээ байгуулах тохиолдол элбэг байдаг.

#### Хайгуул

Ашигт малтмалын эрэл хайгуул хийхийн тулд бүх компани **хайгуулын тусгай зөвшөөрөл** авах ёстой. Түүнчлэн байгаль орчны эрсдэлийн үнэлгээ, тэдгээрийг шийдвэрлэх төлөвлөгөөг нарийвчлан гаргасан **байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлан**, компанийн хайгуулын ажлыг тодорхойлж Ашигт малтмал, газрын тосны газраар хянуулсан **хайгуулын ажлын төлөвлөгөөг** тус тус

боловсруулах ёстой. 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн 35.2-т заасны дагуу компаниуд эдгээр баримт бичгийн хувийг хайгуулын ажлын талбайдаа байлгах ёстой. Ашигт малтмал, газрын тосны газрын бэлдсэн 2018 оны Ашигт малтмал, газрын тосны статистик мэдээллээс үзэхэд 2018 оны 12-р сарын 31-ний байдлаар нийт 1,405 хайгуулын хүчинтэй тусгай зөвшөөрөл байна.<sup>15</sup>

#### Уурхайн ашиглалт

Компаниуд уурхайн ашиглалтын үе шатад шилжиж үйлдвэрлэл явуулахын тулд **ашиглалтын тусгай зөвшөөрөл, мөн уурхайн талбай байгуулж хил хязгаарыг тэмдэглэсэн гэрчилгээ** авсан байх ёстой. Мөн тухайн төслийн **техник, эдийн засгийн үндэслэлийг** боловсруулсан, **байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ** хийсэн, байгаль орчны эрсдэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх, эрсдэлийг хэрхэн багасгах стратегиа тодорхойлсон **байгаль орчны менежментийн төлөвлөгөө** боловсруулсан байх ёстой. 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн 35.3-т зааснаар компаниуд энэ бүх баримт бичгийн хувийг болон **хөрөнгө түрээслэх, бүтээгдэхүүн борлуулах гэрээнүүдээ** уурхай дээрээ байлгах ёстой. Ашигт малтмал, газрын тосны газрын бэлдсэн 2018 оны Ашигт малтмал, газрын тосны статистик мэдээллээс үзэхэд 2018 оны 12-р сарын 31-ний байдлаар нийт 1,673 ашиглалтын хүчинтэй тусгай зөвшөөрөл байна.<sup>16</sup>

#### Уурхайг хаах

Ашиглалт явуулж уурхайн нөөц шавхагдсаны дараа уурхайг хаах тусгай шаардлагуудыг 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн 45 дугаар зүйлд заажээ. Үүний дотор компаниуд уурхайн үйлдвэрлэлийн улмаас үүсэж бий болсон **аюултай, аюул учруулж болзошгүй газруудыг тэмдэглэсэн нарийвчилсан газрын зураг** бэлтгэх ёстой. Одоогоор ийм нарийвчилсан газрын зураг хэдийг бэлтгээд байгаа нь тодорхойгүй байна.

#### Нэмэлт гэрээнүүд

Ашиглалтын шатанд яваа компаниуд тухайн төслийн онцлог шинж, эрэлт хэрэгцээнээс хамаарч төв засгийн газар, орон нутгийн захиргаа, төрийн өмчит үйлдвэрийн газруудтай төрөл бүрийн нэмэлт гэрээ байгуулж болно. Компаниуд ба засгийн газар төслийн үйл ажиллагаатай холбоотой урьдчилан тохиролцсон асуудлуудаар гэрээ чөлөөтэй байгуулж болох учраас энэхүү жагсаалт үүгээр дуусахгүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.<sup>17</sup>

#### Төв засгийн газартай байгуулах гэрээнүүд

- **Хөрөнгө оруулалтын гэрээ** – 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн 29 дүгээр зүйл, Цөмийн энергийн тухай хуулийн 30 дугаар зүйлд зааснаар хөрөнгө оруулалтын гэрээг томоохон хөрөнгө оруулагчдын ажиллах орчныг тогтворжуулах зорилгоор хийдэг.<sup>18</sup> Хөрөнгө оруулалтын гэрээг уул уурхайн төслийн эхний таван жилд 50 сая доллароос багагүй хөрөнгө оруулах компаниудын хүсэлтээр эсхүл уран олборлож буй компанитай хийж болно. Одоогоор хөрөнгө оруулалтын зургаан гэрээ байгуулагдаад байгаа гэж ойлгогддог ч түүнээс ч олон байж болох талтай. Эдгээрээс нийтэд ил

15 [www.mrpam.gov.mn/public/pages/131/monthly.report.2018.12.eng.pdf](http://www.mrpam.gov.mn/public/pages/131/monthly.report.2018.12.eng.pdf)-г үзнэ үү.

16 Өмнөхтэй ижил

17 Жишээлбэл, 2010 оны 6 дугаар сард Оюу Толгой компани Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамтай Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж мэргэжлийн боловсрол, сургалтын салбарыг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар болсон байна.

18 Засгийн газар энэ зорилгоор өмнө нь тогтворжуулалтын гэрээ, харин сүүлийн үед тогтворжуулалтын гэрчилгээ хэмээх баримт бичгийг олгож ирсэн. 1990-өөд онд ийм гурван гэрээ олгосон (бүгд өдгөө хүчингүй болсон) бол сүүлд Энержи Ресурс ХХК-ийн Ухаа худгийн нүүрсний ордын төсөл, Алтайн Хүдэр компанийн Таян нуурын төмрийн хүдрийн ордын төсөл, Ачит Ихт ХХК-ийн катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийн хувьд тогтворжуулалтын гэрчилгээ олгосон.

болсон ганц гэрээ байгаа нь 2009 онд байгуулагдсан Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээ юм.<sup>19</sup> Үлдсэн таван гэрээ нийтэд ил болоогүй боловч хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журмыг (Засгийн газрын 52 дугаар тогтоол) мөрдөж байгаа гэх мэдээлэл бий.<sup>20</sup>

- **Орд ашиглах гэрээ** – 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн 5.3, 5.4 дүгээр зүйлд зааснаар улсын төсвийн хөрөнгөөр эрэл, хайгуул хийж нөөцийг нь тогтоосон (ихэвчлэн 1990 оноос өмнөх дэглэмийн үед олж тогтоосон) ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орд ашиглах гэрээгээр тодорхойлдог. Бидний мэдэж байгаагаар Орд ашиглах нэг гэрээг Арева Майнс ХХК-тай байгуулсан. Энэ гэрээ нийтэд ил болоогүй. Нийт хэдэн орд ашиглах гэрээ байгаа нь тодорхойгүй бөгөөд нэг нь ч нийтэд ил болоогүй байна.
- **Хувьцаа эзэмших буюу хамтарсан үйлдвэрийн гэрээ** – “Стратегийн ач холбогдол бүхий орд” гэж тогтоосон ордуудад төр хувь эзэмших эрхтэй. Энэ тохиолдолд хувьцаа эзэмших эсхүл хамтарсан үйлдвэрийн гэрээг засгийн газар эсхүл төрийн өмчит үйлдвэрийн газартай байгуулдаг. Мэдээж эдгээр гэрээг орд ашиглах гэрээнд нэмэлт болгож байгуулж болно. Энэ төрлийн гэрээний хамгийн тод жишээ бол төр 34% эзэмшиж байгаа Оюу Толгойн гэрээ юм. Энэ гэрээ нийтэд ил болсон. Үүнээс бусад ямар ч хувьцаа эзэмших буюу хамтарсан үйлдвэрийн гэрээ нийтэд ил болоогүй байгаа бөгөөд засгийн газар ийм хэдэн гэрээ хийсэн нь тодорхойгүй байна.<sup>21</sup>
- **Операторын үйлчилгээний гэрээ** – Төрийн өмчит үйлдвэрийн газрууд, тухайлбал коксжих нүүрсний Таван Толгойн ордыг эзэмшигч Эрдэнэс Таван Толгой компани оператор компаниуд ашиглаж орд газрын олборлолтыг тодорхой төлбөртэйгөөр хийлгэж байгаа бөгөөд ашиглалтын тусгай зөвшөөрөл нь тус төрийн компанийн мэдэлд байна. Ийм гэрээ хэд байгаа тухай мэдээлэл байхгүй бөгөөд нийтэд ил болгосон гэрээ байхгүй байна.
- **Нөхөн төлбөр төлөх гэрээ** – Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлд зааснаар улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон ордод олборлолт явуулж буй компани хайгуулын ажилд гарсан зардлыг улсын төсөвт нөхөн төлөх ёстой гэсэн нөхцөлийг нөхөн төлбөр төлөх гэрээнд заадаг (ялангуяа 1990 оноос өмнө нээж илрүүлсэн ордуудад түгээмэл байдаг). Ийм нөхөн төлбөр төлөх гэрээ нийт хэд байгаа нь тодорхойгүй боловч уг гэрээний загвар Ашигт малтмал, газрын тосны газрын вэбсайт дээр байдаг.<sup>22</sup>
- **Нууцлалын гэрээ** – Ашигт малтмалын тухай хуулийн 57.2 дугаар зүйл, Цөмийн энергийн тухай хуулийн 11.2 дугаар зүйл, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 38.2 дугаар зүйлд зааснаар хайгуулын ажлын тайлан, уурхайн ашиглалт, техник, эдийн засгийн үндэслэлтэй холбоотой мэдээллээ тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд нууцлахыг хүссэн

19 Монголын эрдэс баялгын гэрээний мэдээллийн санд Оюу Толгойн хөрөнгө оруулалтын үндсэн гэрээ бий: <http://www.resourcecontracts.mn/contract/55/view>; илүү дэлгэрэнгүй багц баримт бичгүүд Оюу Толгой компанийн доорх вэбсайтад бий <http://ot.mn/%D0%B3%D1%8D%D1%80%D1%8D%D0%BD%D2%AF%D2%AF%D0%B4/>

20 Нийтэд ил болгоогүй хөрөнгө оруулалтын таван гэрээнд Монголын Алт МАК ХХК -тай байгуулсан Цагаан суваргын зэс молибденийн уурхай; Монголын Алт МАК ХХК -тай байгуулсан Хөх цавын цемент, шохойн чулууны үйлдвэрийн төсөл; Монполимет ХХК-тай байгуулсан Монцемент үйлдвэрийн төсөл; Бодь Интернэйшнл ХХК, Поверчайна Ресурсис лимитед компанитай байгуулсан Бөөрөлжүүтийн нүүрсний уурхай, цахилгаан станцын төсөл; Таван толгой Цахилгаан Станц ХХК, ЭмСиЭс Пауэр ХХК-тай байгуулсан Таван толгойн цахилгааны станцын төслийн хөрөнгө оруулалтын гэрээ орно

21 Бидний мэдэж байгаагаар Арева Майнс ХХК-ийн хувьцааны 34 хувийг төрийн өмчит Эрдэнэс Монгол компанийн салбар МонАтом компанид шилжүүлэх хамтарсан үйлдвэрийн нэг гэрээ дор хаяж зурагдсан. Эрдэнэс Монгол төрийн өмчит компанийн 2017 жилийн тайлангаас үзнэ үү.

22 <https://www.mrpam.gov.mn/article/114/-c> үзнэ үү.

компаниудад зориулагдсан байдаг (Шигтгээ 3-г үзнэ үү). Бидний мэдэж байгаагаар энэ төрлийн цорын ганц гэрээг Арева Монгол ХХК байгуулсан байдаг.

*Орон нутгийн захиргаатай байгуулах гэрээ<sup>23</sup>*

- **Хамтын ажиллагааны гэрээ** – Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн дагуу компаниуд байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг хөгжүүлэх, уурхайн ашиглалт, ажил эрхлэлтийн асуудлаар хэрхэн хамтран ажиллахаа тодорхойлж орон нутгийн захиргаатай хамтын ажиллагааны гэрээ байгуулах шаардлагатай. Эдгээр гэрээний нөхцөлүүд орон нутгийн хүн амын хувьд чухал ач холбогдолтой байж болно. Зарчмын хувьд төсөл бүрд дор хаяж нэг хамтын ажиллагааны гэрээ байх ёстой боловч бодит байдалд хамтын ажиллагааны гэрээ хараахан байгуулаагүй олон төсөл байдаг. Монголын эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санд хамтын ажиллагааны 70 гэрээ бий. Нийтэд ил болгоогүй өөр олон гэрээ байгаа эсэх нь тодорхойгүй байна.
- **Газар, ус ашиглалтын гэрээ** – Бүх төслийн хувьд орон нутгийн захиргаатай газар ашиглалтын болон ус ашиглалтын гэрээ байгуулах шаардлагатай. Монголын эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санд газрын түрээсийн 125 гэрээ, ус ашиглалтын 48 гэрээ байна. Нийтэд ил болгоогүй өөр олон гэрээ байгаа эсэх нь тодорхойгүй байна.
- **Орон нутгийн бусад гэрээ** – Компаниуд мөн орон нутгийн захиргаатай бичил уурхай (БУ), орон нутгийн ажил эрхлэлт, орон нутгийн хөгжлийн гэрээ байгуулдаг. Ийм гэрээ хэд байгаа, тэдний хэдийг нь нийтэд ил болгосон нь тодорхойгүй байна.

*Цацраг идэвхт ашигт малтмал олборлох тусгай гэрээнүүд*

Цацраг идэвхт ашигт малтмалтай холбоотой хэд хэдэн гэрээ, холбогдох бусад баримт бичиг шаардлагатай. Монголд ашиглалтын шатанд байгаа ямар нэг ураны төсөл одоогоор байхгүй учраас эдгээр гэрээг байгуулаагүй гэж ойлгож байна.

- **Орд ашиглах гэрээ** – Цөмийн энергийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу Орд ашиглах гэрээнд тухайн ордыг хөгжүүлэхэд мөрдөх үндсэн дүрмүүдийг тогтоодог<sup>24</sup>.
- **Баталгааны гэрээ** – Цөмийн энергийн тухай хуулийн 28.8-д заасны дагуу Баталгааны гэрээ нь уул уурхайн компаниуд цөмийн материалын тоо, хэмжээ, түүнд орсон өөрчлөлт, алдагдал, хорогдол, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой мэдээллийг зааврын дагуу тогтоосон хугацаанд үнэн зөвөөр гаргаж төрийн захиргааны байгууллагад өгөх үүргийг тодорхойлдог.
- **Цацрагийн ослоос сэргийлэх төлөвлөгөө** – Цөмийн энергийн тухай хуулийн 45 дугаар зүйлд зааснаар цөмийн болон цацрагийн ослоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөө нь тухайн төслийг явуулахтай холбоотой аюулгүй байдлын онцгой мэдээллээр хангаж байдаг.

<sup>23</sup> Дэлгэрэнгүй мэдээллийг Бямбажав Далайбуян, Монголын эрдэс баялгийн салбар дахь Орон нутгийн түвшний гэрээнүүд: Авсан сургамж, цаашдын арга зам, 2017 оны 12-р сарын 5, <https://resourcegovernance.org/analysis-tools/publications/local-level-agreements-mongolia-resource-sector-lessons-learned-english> бүтээлээс үзнэ үү.

<sup>24</sup> Үүнд цацраг идэвхт ашигт малтмалын орд ашиглах үндэслэл; цацраг идэвхт ашигт малтмалын орд ашиглах хугацаа, цацраг идэвхт ашигт малтмалын нэр төрөл, агуулга, нөөцийн хэмжээ; техник, эдийн засгийн үндэслэлд тусгагдсан технологи, үйлдвэрлэлийн хүчин чадал, олборлох бүтээгдэхүүний тоо хэмжээ; бүтээгдэхүүн борлуулах нөхцөл; байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх зардлын хэмжээ; уурхайг хаах ерөнхий төлөвлөгөө; гэрээнд оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага орно.

### Газрын тосны салбарын гэрээнүүд ба холбогдох баримт бичгүүд

Монголд газрын тосны салбарт хайгуул, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахыг хүссэн компаниуд Монгол Улсын Засгийн газартай БХГ байгуулах ёстой. Одоогоор Монголд идэвхтэй 25 БХГ байгаа боловч нэг нь ч нийтэд ил болоогүй байна. Өмнө нь АНУ болон Канадын хөрөнгийн биржийн тайлагнах шаардлагын үр дүнд гурван БХГ нийтлэгдээд байсан боловч бүгд хугацаа нь дууссан байна.<sup>25</sup>

#### Хайгуул

Хайгуулын тусгай зөвшөөрөл авахын тулд компаниуд татвар, санхүүгийн янз бүрийн чухал нөхцөлийг нарийвчлан заасан **БХГ**-г засгийн газартай байгуулах ёстой. Тэд мөн хайгуулын хугацаанд **байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ** хийж, **байгаль орчны хамгаалалт, нөхөн сэргээлтийн тайлан** гаргаж, компанийн үүргийг нарийвчлан тогтоосон **хайгуулын ажлын батлагдсан төлөвлөгөөтэй** байх ёстой. Хэрэв орд газар нь хоёр ба түүнээс дээш хайгуулын талбайг хамарсан бол компаниуд **хайгуулын хамтарсан төлөвлөгөө** гаргах ёстой.

#### Олборлолт

Уул уурхайн салбараас ялгаатай нь, компаниуд газрын тосны үйлдвэрлэлийн шатанд шилжихдээ хайгуулын шатанд байгуулсан БХГ-ний дагуу үргэлжлүүлэн ажилладаг (гэхдээ тэд анхны БХГ-дээ нэмэлт өөрчлөлт оруулж болно). Энэхүү БХГ-ээс гадна компаниуд хайгуулын үе шатанд зориулсан **байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ** хийж, **байгаль орчны хамгаалалт, нөхөн сэргээлтийн тайлан** гаргадаг. Тэд жил бүр хийх ажлаа нарийвчлан тодорхойлсон **ажлын тайлан, төсөв** гаргаж ирүүлэх шаардлагатай. Мөн уул уурхайн салбарын нэг адилаар, газрын тосны компаниуд орон нутгийн захиргааны байгууллагуудтай **хамтын ажиллагааны гэрээ** байгуулах шаардлагатай. Одоогийн байдлаар газрын тосны үйлдвэрлэл явагдаж буй гурван газар байна.<sup>26</sup>

25 Эдгээр гэрээ доорх хаягт бий: <https://www.resourcecontracts.org/search?q=&country%5B%5D=MN&resource%5B%5D=Gas&resource%5B%5D=Hydrocarbons>.

26 Эдгээр нь Петрочайна Дачин Тамсаг компанийн эзэмшиж буй Тосон Уул XIX талбай, Тамсаг XXI талбай, мөн Дон Шен Жингонг Петролиум Девелопмент Группын эзэмшиж буй PSA-97 талбай юм. Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга, ОУИТБС-ын 11 дүгээр нэгтгэл тайлан 2016, 2017 оны 11 дүгээр сар, [https://eti.org/sites/default/files/documents/2016\\_m\\_eiti\\_report\\_final\\_english.pdf](https://eti.org/sites/default/files/documents/2016_m_eiti_report_final_english.pdf) -г үзнэ үү.

Хүснэгт 1 – Монголд мэдэгдэж буй хүчин төгөлдөр гэрээний баримт бичгүүд ба тэдгээрийг нийтэд ил болгосон байдлын тойм

Салбар	Үе шат	Баримт бичиг	Баримжаа тоо	Нийтэд ил болсон тоо
Уул уурхай	Хайгуул	<b>Үндсэн баримт бичгүүд:</b> <ul style="list-style-type: none"> <li>Хайгуулын тусгай зөвшөөрөл</li> <li>Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлан</li> <li>Хайгуулын ажлын төлөвлөгөө</li> </ul>	~1400	0
	Ашиглалт	<b>Үндсэн баримт бичгүүд:</b> <ul style="list-style-type: none"> <li>Ашиглалтын тусгай зөвшөөрөл</li> <li>Уурхайн талбайн хил хязгаарыг тогтоож тэмдэглэсэн гэрчилгээ</li> <li>Техник, эдийн засгийн үндэслэл</li> <li>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ</li> <li>Байгаль орчны менежментийн төлөвлөгөө</li> <li>Хөрөнгө түрээслэх, бүтээгдэхүүн борлуулах гэрээ</li> </ul>	~1700	0
		<b>Төв засгийн газартай байгуулах нэмэлт гэрээнүүд:</b> <ul style="list-style-type: none"> <li>Хөрөнгө оруулалтын гэрээ</li> <li>Орд ашиглах гэрээ</li> <li>Хувьцаа эзэмших буюу хамтарсан үйлдвэрийн гэрээ</li> <li>Операторын үйлчилгээний гэрээ</li> <li>Нөхөн төлбөр төлөх гэрээ</li> <li>Нууцлалын гэрээ</li> </ul>	6 ? ? ? 1 1	1 0 1 0 0 0
		<b>Орон нутгийн захиргаатай байгуулах гэрээнүүд:</b> <ul style="list-style-type: none"> <li>Хамтын ажиллагааны гэрээ</li> <li>Газар, ус ашиглалтын гэрээ</li> <li>Орон нутгийн бусад гэрээ</li> </ul>	? ? ?	70 173 ?
		<b>Цацраг идэвхт ашигт малтмалын гэрээнүүд:</b> <ul style="list-style-type: none"> <li>Орд ашиглах гэрээ</li> <li>Баталгааны гэрээ</li> <li>Цацрагийн ослоос сэргийлэх төлөвлөгөө</li> </ul>	0 0 0	0 0 0
	Хаалт	<ul style="list-style-type: none"> <li>Аюултай, аюул учруулж болзошгүй газруудыг тэмдэглэсэн нарийвчилсан газрын зураг</li> </ul>	?	?
Газрын тос	Хайгуул	<b>Үндсэн баримт бичгүүд:</b> <ul style="list-style-type: none"> <li>Бүтээгдэхүүн хуваах гэрээ</li> <li>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ</li> <li>Байгаль орчны хамгаалалт, нөхөн сэргээлтийн тайлан</li> <li>Хайгуулын ажлын төлөвлөгөө</li> </ul>	25 ?	0 ?
	Үйлдвэрлэл	<b>Үндсэн баримт бичгүүд:</b> <ul style="list-style-type: none"> <li>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ</li> <li>Байгаль орчны хамгаалалт, нөхөн сэргээлтийн тайлан</li> <li>Ажлын төлөвлөгөө, төсөв</li> <li>(Орон нутгийн захиргаатай) Хамтран ажиллах гэрээ</li> </ul>	3	0

### 3. ЗАСГИЙН ГАЗАР ИЛ НИЙТЛЭХ ЯВДЛЫГ ХЭРХЭН ХАНГАХ ВЭ?

#### Алхам 1: Гэрээний нөхцөл байдлыг тайлбарлах.

Эхний алхам болгож Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газраас засгийн газар, төрийн өмчит компаниудын газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниудтай байгуулсан хүчинтэй байгаа бүх гэрээний жагсаалтыг шинэчилж, нийтлэх хэрэгтэй. Энэ нь иргэд, компаниуд Монгол дахь гэрээний орчин нөхцөлийг илүү сайн ойлгоход туслаад зогсохгүй төр засгаас гэрээг ил болгох чиглэлээр тавьж буй хүчин чармайлтад итгэх итгэлийг

бэхжүүлэх баттай үндэс суурь болох юм. Энэ жагсаалтыг Хүснэгт 1-д үзүүлсэн нэгдсэн мэдээлэлд тулгуурлан хөгжүүлж болно. Зүй нь байгуулсан гэрээний нийт тоо, эзэмшиж буй компанийн нэрийг гэрээний төрөл бүрээр харуулсан, гэрээнд ямар нэг нэмэлт өөрчлөлт орсон эсэхийг заасан байвал зохино.

## Алхам 2: Ил тод болгох цар хүрээг тодорхойлох.

Дараа нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас нийтэд ил болгох цар хүрээ, арга замыг тодорхойлох ёстой. Энэхүү судалгааны 2-р хэсэгт харуулсан бүх гэрээ, холбогдох баримт бичгийг нийтэд ил болгох олон нийтийн сонирхол их байгаа бөгөөд Нээлттэй засгийн түншлэлийн Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөнд засгийн газрын авсан үүрэг амлалт бол эдгээр баримт бичгийг хамруулахад хангалттай өргөн хүрээтэй үндэслэл юм. Гэвч энэ бүх баримт бичгийг нийтлэхэд багагүй хүчин чармайлт шаардагдах учраас яамнаас эдгээр баримт бичгийг үе шаттайгаар ил болгох дараалал тогтоож, ажлаа цэгцтэй болгож болох юм.

Юуны өмнө Засгийн газар бүгдийг нь биш ч заримыг нь нийтлээд байгаа гэрээний тодорхой төрлүүдийг системтэйгээр нийтэд ил болгож эхлэхийг санал болгож байна. Үүнд уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын гэрээнүүд, хамтарсан үйлдвэрийн буюу хувь нийлүүлэх гэрээнүүд, газрын тосны салбар дахь БХГ-үүд, дээрх салбарт орон нутгийн захиргаатай байгуулсан хамтын ажиллагааны гэрээнүүд орно. Рио Тинто гэх мэт компаниуд эдгээр баримт бичгийг тохиолдлын байдлаар нийтэлсэн нь нийтэд ил болгохтой холбоотой эрсдэл цөөн гэдгийг харуулсан. Гэрээг системтэйгээр нийтлэх нь Монголд үйл ажиллагаа явуулж буй бүх компанид ижил шаардлага тавих нөхцөл бүрдэх бөгөөд гэрээ нь хараахан ил болоогүй байгаа бусад төслийн талаарх иргэдийн эргэлзээ таамгийг багасгана. Ийм аргыг хэрэглэхийн ач холбогдол нь холбогдох баримт бичгийн тоо харьцангуй цөөн, тэдгээрийг нийтлэх олон нийтийн сонирхол их байгаатай холбоотой. Эдгээр баримт бичиг ил болсны дараа яамнаас стандартжуулсан тусгай зөвшөөрөл, гэрээнүүд болон гэрээний загваруудыг нийтлэх чиглэлд анхаарлаа хандуулж болно.

Өөр нэг хувилбар бол засгийн газар үндэсний болон орон нутгийн оролцогч талуудад тэргүүлэх ач холбогдолтой баримт бичгүүдийг ангилж, нэн түрүүнд сонгож болох юм. Үүнд орон нутагт үзүүлэх нөлөө талаасаа байгаль орчны баримт бичгүүд, хамтын ажиллагааны гэрээнүүд, мөн үндэсний хэмжээнд төсөв санхүүгийн үр нөлөөтэй талаасаа хөрөнгө оруулалтын гэрээ, орд ашиглах гэрээ, хамтарсан үйлдвэр, хувь нийлүүлэх гэрээнүүд орж болно. Орон нутгийн захиргааны гэрээг нийтэлсэн байдал нь өөрөө энэ төрлийн дараалал тогтоох нэг жишээ юм. Бас нэг хувилбар бол засгийн газар төсөл бүрийн үндсэн баримт бичиг болон загвар гэрээг эхэлж нийтлэх явдал байж болно. Энэ аргын давуу тал нь эдгээр баримт бичгийг стандартжуулсан учраас түүнийг ил болгохыг эсэргүүцэгчдийн зүгээс шүүмжлэл ирэх магадлал бага байна. Эдгээр баримт бичиг нийтэд ил болсны дараа яамнаас илүү нарийн төвөгтэй баримт бичгүүдийг нийтлэхэд анхаарч болно.

## Алхам 3: Гэрээ ил болгох дүрмийг тогтоох.

Нэгдүгээр хэсэгт авч үзсэнчлэн, Монгол Улсад орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнүүд, байгаль орчны баримт бичгүүдийг ил болгохыг шаардсан хууль дүрмүүд бий. Эдгээр дүрмийг өргөтгөн энэхүү судалгаанд авч үзсэн бусад төрлийн гэрээнд үйлчилдэг болгохын зэрэгцээ заавал богино хугацаанд ил болгохыг албадахгүй байх нь гэрээний ил тод байдлыг урт хугацаанд системтэй, тэгш шударга байдлаар хангах зөв зүйтэй арга зам байх болно.

Гэрээг нийтэд ил болгох дүрэм тогтоох нэг шуурхай арга бол засгийн газрын

зохих захирамж шийдвэрийг гаргах явдал юм. Ийм шийдвэрийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар хялбархан гаргаж болох бөгөөд ингэснээр тус яам Нээлттэй Засгийн Түншлэлд заасан үүрэг амлалтаа шуурхай биелүүлэх боломж бүрдэнэ. Харин үүнээс илүү сайн дүрэм бол хууль тогтоомжийн хэлбэрээр гаргах явдал буюу магадгүй Ашигт малтмалын тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтөд хамруулж болох юм. Өөр бас нэг хувилбар буюу магадгүй хууль тогтоомж, захирамжид нэмэлт болгон хийж болох зүйл бол засгийн газар гэрээг ил болгох шаардлагыг ашигт малтмал, газрын тосны салбарт шинээр тусгай зөвшөөрөл олгох тендерийн нөхцөлд оруулах явдал юм. Энэ нь цаашид бүх компани тусгай зөвшөөрөл авах, гэрээ байгуулах хүсэлт гаргахаас өмнө уг бодлогыг мэддэг болох ач холбогдолтой.

Зүй нь гэрээний ил тод байдлын тухай заалтад дараах зүйлсийг оруулах нь зохистой:

- Яг юуг тусгайлан ил болгох вэ (тэргүүн туршлагаас үзэхэд бүх “идэвхтэй” гэрээний бүрэн эх, аливаа хавсралт, нэмэлт хэсгийн бүрэн эх, ямар нэг өөрчлөлт, нэмэлт өөрчлөлтийн бүрэн эх текстийг оруулдаг)<sup>27</sup>
- Гэрээнд гарын үсэг зурснаас хойш нийтлэх бодитой хугацаа
- Ил болгосон гэрээний хэлбэр (хайлт хийж болохуйц цахим файл), түгээх суваг

#### Алхам 4: Гэрээнүүдийг хүртээмжтэй болгох.

Монгол Улсын хувьд нэн тэргүүний зорилт бол гэрээнүүдийг нийтэд ил болгох явдал бөгөөд харин дунд хугацаанд эдгээр гэрээг олж үзэх, эрж хайх, ашиглахад хялбар болгох явдал байх ёстой.<sup>28</sup> Үүний тулд засгийн газрын гэрээний мэдээллийн сан болох [www.resourcecontracts.mn](http://www.resourcecontracts.mn) дээр дараах боломжийг нэмж оруулж болно.

##### *Компьютероор уншигдах хэлбэрийг ашиглах.*

Компьютерт уншигдах хэлбэр нь одоогийн хэрэглэж буй зөвхөн унших зориулалттай дүрс хэлбэрийн файлаас илүү гэрээг хэрэглэхэд хялбар болгодог. Ийм хэлбэрээр хадгалсан гэрээнээс ямар нэг тодорхой нөхцөл (жишээлбэл, нөөц ашигласны төлбөрийн хувь) хайх хэрэгтэй бол заавал гэрээг бүхэлд нь унших шаардлагагүй. Харин үүний оронд “нөөц ашигласны төлбөр” гэсэн түлхүүр үгийг оруулаад хайлт хийхэд хайсан зүйлээ олох бөгөөд гэрээний хуудас болгоныг уншиж үзэх хэрэггүй болно. Энэ технологийг одоогийн сайтад нэвтрүүлэхэд харьцангуй хялбар байх болно. Учир нь Монголын вэбсайтын суурилж буй [resourcecontracts.org](http://resourcecontracts.org) платформд угаасаа байдаг нийтлэг онцлог юм.<sup>29</sup>

##### *Өөр өөр байгууллагын баримт бичгүүдийг нэгтгэх.*

Гэрээг бүрэн ил болгохын тулд олборлох үйлдвэрийн төсөл бүрийн хувьд 2-р хэсэгт дурдсан бүх гэрээ, дагалдах баримт бичгийг оруулна. Эдгээр баримт бичгүүд хэд хэдэн байгууллагуудад хадгалагдаж байж болно.

<sup>27</sup> Гэрээний бүрэн эхийг ил болгох нь Монголын практикт аль хэдийн хэрэглэгдэх болсон жишиг юм. Гэрээ маш олон нарийвчилсан, харилцан уялдаатай нөхцлүүд агуулдаг учраас энэ аргыг хэрэглэх нь чухал. Иймд гэрээний бүрэн эх буюу бүх тексттэй хувилбарыг ашиглах нь бодит баримт бичгийн оронд гэрээний баримт бичгийг хагас дутуу, зөв буруу нэгтгэж хураангуйлснаас үүсч болох мушгин гуйвуулалт, буруу ойлголт, үл итгэлцлийн асуудлаас зайлсхийхэд туслана.


<sup>28</sup> Дэлхийн улс орнуудын засгийн газрууд гэрээг хуваарилах, удирдах бүхий л үйл явцад хэрэглэдэг нийтэд ил болгох дэлхий нийтийн тэргүүн туршлагын тоймыг ББЗХ-ийн Газрын тос, байгалийн хий, уул уурхайн эрхийн нээлттэй гэрээлэлт, 2018, <https://resourcegovernance.org/analysis-tools/publications/open-contracting-oil-gas-and-mineral-rights> хаягаар үзнэ үү.

<sup>29</sup> Баялгийн гэрээнүүд вэб сайтыг [resourcecontracts.org](http://resourcecontracts.org) хаягаар үзнэ үү.



Жишээ нь, үндсэн гэрээг Ашигт малтмал, газрын тосны газарт, хамтын ажиллагааны гэрээг орон нутгийн захиргаанд хадгалж байж болно. Хэрэглэгчид хайж байгаа зүйлээ эрж олоход хялбар болгох үүднээс олон байгууллагад байгаа баримт бичгийг нэг мэдээллийн санд нэгтгэж оруулж буй засгийн газар олон байна. Цаашилбал, эдгээр портал санд буй мэдээллийг төсөл бүрээр ангилж оруулснаар хэрэглэгчид тэнд тавигдсан мэдээллийг илүү ойлгоход туслахаас гадна холбогдох мэдээллийг олж үзэх боломжтой болно. Үүний нэг шилдэг жишээ бол Мексик улсын нүүрс устөрөгчийн үйлдвэрлэлийн үндэсний комиссын боловсруулсан портал сайт юм. Тус сайтад газрын тосны төсөл бүрд зориулсан хуудас нээж түүндээ гэрээний бүрэн эх, ажлын хөтөлбөрүүд, орон нутгийн ажиллах хүч ба хангамжийн дүрмүүд, байгаль орчны баримт бичгүүд, түүний дотор байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, холбогдох судалгаа, менежментийн төлөвлөгөөнүүдийг оруулсан байна (Зураг 1-г үзнэ үү).<sup>30</sup>

Зураг 1. Мексик улсын нүүрс устөрөгчийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг зохицуулагчийн вэбсайтад зохицуулалтын төрөл бүрийн хүрээтэй холбоотой мэдээллийг төслийн хувьд нэгтгэсэн жишээ



### Алхам 5: Гэрээг ашиглахыг дэмжих.

Гэрээ, тусгай зөвшөөрлүүдийг нийтэд ил болгосноор Монгол Улсын хүчин чармайлт дуусахгүй. Засгийн газар, компаниуд, иргэд гэрээний ил тод байдлын ашиг тусыг хүртэхийн тулд Монгол Улсын Засгийн газраас гэрээний ашиглалтыг нэмэгдүүлэх санаачилгуудыг дэмжиж ажиллах хэрэгтэй. Үүнд гэрээний ил тод байдлыг засгийн газрын мэдээлэл харилцааны стратегид оруулах, гэрээний үг хэллэгийг энгийнээр тайлбарлахад мэдээллийн хэрэгслүүдийг ашиглах явдал орж болно. Мөн засгийн газраас олборлох үйлдвэрлэлийн гэрээнүүдийн нарийн утга агуулга, тэдгээрийн олборлох үйлдвэрлэлийн засаглалд үзүүлэх нөлөөг илүү сайн таниулах чиглэлээр төв, орон нутгийн засгийн газрын хэмжээнд төрийн албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх сургалт, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулахад анхаарч болно.

<sup>30</sup> <http://rondasmexico.gob.mx> –с үзнэ үү.

---

## ТАЛАРХАЛ

Дарамбазарын Тэгшбаярын урьдчилсан судалгаа, Намхайжанцангийн Дорждарь болон Амир Шафай-ын санал, зөвлөмжгүйгээр энэхүү хураангуй гарах боломжгүй байв.

Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн нь бодлогын судалгаа хийх, чадавх хөгжүүлэх, техникийн туслалцаа үзүүлэх, нөлөөллийн үйл ажиллагааг дэмжих замаар тухайн улс орны иргэд газрын тос, байгалийн хий, уул уурхайн баялгийнхаа үр шимийг хүртэхэд туслалцаа үзүүлдэг олон улсын хараат бус, ашгийн бус байгууллага юм.

Нэмэлт мэдээллийг [www.resourcegovernance.org](http://www.resourcegovernance.org) вэбсайтаас авна уу.



Oil, gas and mining for development